

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 11 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 234

Улаанбаатар хот

Г Хорооны 2008 оны 291 дүгээр тогтоолд Г
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5, 6.2.4, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 291 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ын 2.8 дахь заалтыг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1.“2.8.Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын мэргэжлийн оролцогчоос жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг дараах байдлаар тогтооно:

2.8.1.Даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс:

Д/д	Зохицуулалтын үйлчилгээний төрөл	Төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /төгрөгөөр/
1	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх	
	1.1.Улаанбаатар хот	20000
	1.2.Улаанбаатар хотоос бусад орон нутагт	10000
2	Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх	
	1.1.Улаанбаатар хот	300000
	1.2.Улаанбаатар хотоос бусад орон нутагт	150000

2.8.2.Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг өмнөх оны даатгалын хохирол үнэлгээний хураамжийн орлогоос 0.55 хувиар тооцно.

2.8.3.Энэхүү журмын 2.8.2-т заасан зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ 300000 /гурван зуун/ мянган төгрөгөөс бага байвал тухайн даатгалын хохирол үнэлэгч

компаниас тухайн онд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 300000 /гурван зуун/ мянган төгрөгөөр тооцно.

2.Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН